



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ 2016-2019 ОН

#ОлонНийтийнГазар #ТөлчиглэмийГазар #ЗамынХөдөлгөөн #НийтийнГазар #ЦахимОрчин

ХОТ **СОЁЛТОЙ**
БОЛГОЁ

#Хамтдаавөрчилъё

www.ubstat.com/mn/ubstat www.ubstat.com/mn/ubstat www.ubstat.com/mn/ubstat



Улаанбаатар хот
2020 он

АГУУЛГА

1.Тодорхойлолт.....	2
2. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл.....	3
3. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт.....	7

ТОДОРХОЙЛОЛТ

Нийт үйлдвэрлэл Тайлант хугацаанд шинээр үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний нийт дүн (тухайн оны үнээр)-г хэлнэ.

Бүтээгдэхүүний борлуулалт Тайлант хугацаанд худалдсан буюу бусдад зориулж гүйцэтгэсэн ажил үйлчилгээг хэлнэ. Нийт борлуулалтад тухайн үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн ажил үйлчилгээний борлуулалтад орно. Хэрэв захиалагч бүтээгдэхүүнийхээ төлбөрийг урьдчилан төлсөн бол уг бүтээгдэхүүнийг борлуулагдсан гэж үзнэ.

Аж үйлдвэрийн борлуулалт Зөвхөн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг хамруулна. Энд үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн, үйлчилгээ, үндсэн хөрөнгө, түүхий эд материал зэргийн худалдан борлуулсан хэмжээг хамруулахгүй.

Бүтээгдэхүүн Зах зээлд нийлүүлэхэд үйлдвэрлэл нь хараахан дуусаагүй бэлэн бус бүтээгдэхүүнийг хэлнэ.

Үндсэн үнэ Аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлд гарсан зардал, ашгаа тооцон багтаасан үнийг үндсэн үнэ гэнэ. Үндсэн үнэд татварыг оруулж тооцохгүй ба татаасыг оруулж тооцно.



АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Статистикийн албан ёсны мэдээнд хамрагдсан аж үйлдвэрийн газруудын нийт үйлдвэрлэл 2019 онд 537721.0 сая төгрөгт хүрсэн нь 2016 оноос 293875.8 (2.2 дахин) сая төгрөгөөр, 2017 оноос 226412.2 (72.7%) сая төгрөгөөр, 2018 оноос 48190.9 (9.8%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Дүүргийн аж үйлдвэрийн газрууд 2019 онд 466971.5 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2016 оноос 234727.4 (2 дахин) сая төгрөгөөр, хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрүүд 70749.5 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2016 оноос 59148.4 (6 дахин) сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл, эдийн засгийн ангиллаар, сая төгрөгөөр

Салбар	2016	2017	2018	2019	$\frac{2019}{2016}$ %
Боловсруулах аж үйлдвэр	243845.2	311308.80	489530.1	537721.0	2.2 дахин
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	232244.1	289597.90	454752.2	466971.5	2 дахин
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	21386.2	30417.00	78038.3	94877.6	4.4 дахин
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	59003.4	89811.90	139097.4	163532.8	2.7 дахин
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	68998.3	84105.40	132067.4	85716.0	124.2
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	40986.8	46652.70	57218.5	70615.3	172.2
Архи, ус, ундаа үйлдвэрлэл	41869.4	38610.90	48330.6	52229.8	124.7
Хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэл	11601.1	21710.90	34777.9	70749.5	6 дахин
Нэхмэлийн үйлдвэрлэл	0	0	0	610.1	-
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	1949.2	5835.80	6553.4	4835.5	2.4 дахин
Мод, модон эдлэл	158.1	31.6	0	0	-
Кокс, шингэн болон цацраг идэвхт түлш	0	0	0	31054.1	-
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	5261.0	10998.80	16802.6	21935.3	4.1 дахин
Резинен болон хуванцар бүтээгдэхүүн	161.8	219.9	283.6	230.0	142.1
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	1675.7	2358.60	8783.3	8364.9	4.9 дахин
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	1502.1	2051.00	2125.5	3079.2	2 дахин
Автомашин, чиргүүл үйлдвэрлэл	0	0	0	625.0	-
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	893.2	215.1	229.4	15.4	1.7

Тайлбар: Статистикийн албан ёсны мэдээнд хамрагдсан аж үйлдвэрийн газруудын дүн

Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл


Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрүүдийн 2019 онд үйлдвэрлэсэн нийт хүнсний бүтээгдэхүүний 20.3 хувийг мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 35.0 хувийг сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 18.3 хувийг үр тарианы гурил, малын тэжээлийн үйлдвэрлэл, 11.1 хувийг архи, ус, ундааны үйлдвэрлэл, 15.1 хувийг хүнсний бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл эзэлж байна.

2019 онд мах махан бүтээгдэхүүний үйлдвэрүүд 94877.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2016 оноос 73491.4 (4.4 дахин) сая төгрөгөөр, сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрүүд 163532.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2016 оноос 104529.4 (2.7 дахин) сая төгрөгөөр, үр тариа гурил, цардуул малын тэжээлийн үйлдвэрүүд 85716.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2016 оноос 16717.7(24.2%) сая төгрөгөөр, хүнсний бусад бүтээгдэхүүний үйлдвэрүүд 70615.3 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2016 оноос 29628.5 (72.2%) сая төгрөгөөр, архи ус ундаа үйлдвэрүүд 52229.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2016 оноос 10360.4 (24.7%) сая төгрөгөөр өссөн байна.

Сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрүүд 2019 онд 18635.2 мян.л боловсруулсан шингэн сүү үйлдвэрлэсэн нь 2016 оноос 3790.5 (25.5%) мян.л-ээр, 8761.4 мян.л тараг үйлдвэрлэсэн нь 2016 оноос 3401.2 (63.4%) мян.л-ээр, 166.6 тн цөцгийн тос үйлдвэрлэсэн нь 2016 оноос 25.8 (18.3%) тн-

оор, 130.2 тн ааруул үйлдвэрлэсэн нь 2016 оноос 19.8 (17.9%) тн-оор өссөн байна. Харин 187.3 тн өтгөн цөцгий үйлдвэрлэсэн нь 2016 оноос 71.3 (27.5%) тн-оор буурчээ.

Зураг 1. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сая төгрөгөөр




Хүснэгт 2. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	$\frac{2019}{2016}$ %
Шингэн сүү	мян.л	14844.7	16165.7	18257.3	18635.2	125.5
Тараг	мян.л	5360.2	6581.5	8927.3	8761.4	163.4
Ааруул	тн	110.4	120.1	120.5	130.2	117.9
Цөцгийн тос	тн	140.8	118.7	111.3	166.6	118.3
Өтгөн цөцгий	тн	258.6	153.4	174.3	187.3	72.4

Тайлбар: Статистикийн албан ёсны мэдээнд хамрагдсан аж үйлдвэрийн газруудын дүн


Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрүүд 2019 онд 14.3 мян.тонн мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2016 оноос 10.0 (3.3 дахин) мян.тн-оор өссөн байна. 2019 онд 2.5 мян.тн хиамны төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2016 оноос 0.9 (56.2%) мян.тн-оор буурсан байна.

Зураг 2. Мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, мянган тонноор



2019 онд гурилын үйлдвэрүүд 24.8 мян.тн дээд гурил үйлдвэрлэсэн нь 2016 оноос 1.9 (8.2%) мян.тн-оор, 42.6 мян.тн гурил I зэрэг үйлдвэрлэсэн нь 2016 оноос 5.5 (14.8%) мян.тн-оор, 6.5 мян.тн гурил II зэрэг үйлдвэрлэсэн нь 2016 оноос 1.9 (41.3%) мян.тн-оор, 8.8 мян.тн гоймон үйлдвэрлэсэн нь 2016 оноос 4.9 (2.2 дахин) мян.тонноор өссөн байна.Талх нарийн боовны үйлдвэрүүд 2019 онд 15.0 мян.тн талх үйлдвэрлэсэн нь 2016 оноос 2.8 (22.9%) мян.тн-оор, 4.8 мян.тн нарийн боов үйлдвэрлэсэн нь 2016 оноос 1.9 (65.5%) мян.тн-оор тус тус өсжээ.

Зураг 3. Гурилын үйлдвэрлэл, нэр төрөл, мянган тонноор



2019 онд цэвэр спирт, архи, ус, ундаа үйлдвэрлэдэг үйлдвэрүүд цэвэр спирт 1637.5 мян.л үйлдвэрлэсэн нь 2016 оноос 517.1 (46.1%) мян.л-ээр, пиво 1050 мян.л үйлдвэрлэсэн нь 2016 оноос 7.4 (0.7%) мян.л-ээр, цэвэр ус 19305 мян.л үйлдвэрлэсэн нь 2016 оноос 8682.9 (81.7%) мян.л-ээр тус тус өсч, архи 4468.7 мян.л үйлдвэрлэсэн нь 2016 оноос 27.6 (0.6%) мян.л-ээр буурсан байна. 2019 онд Дарс 187.2 мян.л, амтат ус ундаа 557.6 мян.л, жүүс 489.4 мян.л үйлдвэрлэсэн байна.

Хүснэгт 3. Архи, ус, ундаа үйлдвэрлэл, мянган литрээр

Бүтээгдэхүүн	2016	2017	2018	2019	$\frac{2019}{2016}$ %
Цэвэр спирт	1120.4	1252	1902.3	1637.5	146.1
Архи	4496.3	3690.1	4539.5	4468.7	99.3
Пиво	1042.6	1114.5	1522.0	1050.0	100.7
Хийжүүлсэн Цэвэр ус, рашаан	10622.6	10755.6	12859.8	19305.7	181.7
Дарс	-	-	-	187.2	-
Амтат ус, ундаа	-	-	-	557.9	-

Тайлбар: Статистикийн албан ёсны мэдээнд хамрагдсан аж үйлдвэрийн газруудын дүн

Хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэл

2019 онд аж үйлдвэрийн газруудын үйлдвэрлэсэн хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 0.8 хувийг нэхмэлийн үйлдвэрлэл, 6.8 хувийг хувцас үйлдвэрлэл, 43.8 хувийг кокс, шингэн болон цацраг идэвхт түлш, 31 хувийг химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 0.3 хувийг резинен болон хуванцар бүтээгдэхүүн, 11.8 хувийг төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл, 4.3 хувийг машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл, 0.8 хувийг автомашин, чиргүүл үйлдвэрлэл, 0.02 хувийг мебель тавилга үйлдвэрлэл эзэлж байна.


Хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрийн газрууд 2019 онд 66.2 мянган ширхэг хувцас үйлдвэрлэсэн нь 2016 оноос 45.3 (3.1 дахин) мянган ширхэгээр, 6540.6 мянган ширхэг эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2016 оноос 4108.8 (2.6 дахин) мянган ширхэг, 698.1 мянган ширхэг хөнгөн блок үйлдвэрлэсэн нь 2016 оноос 441.8 (2.7 дахин) мянган ширхэгээр, 2743.5 ширхэг машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэсэн нь 2016 оноос 656.8 (31.4%) мянган ширхэгээр тус тус өссөн байна. Харин 2019 онд 14 ширхэг мод, модон эдлэл үйлдвэрлэсэн нь 2016 оноос 577 (97.7%) ширхэгээр, 23.1 метр.кв төмөр хаалга цонх үйлдвэрлэсэн нь 2016 оноос 14 (37.7%) метр квадратаар тус тус буурсан байна.

Хүснэгт 4. Хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэр төрлөөр

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	$\frac{2019}{2016}$ %
Хувцас	мян.ш	20.9	54	96.1	66.2	3.1 дахин
Мод, модон эдлэл	ширхэг	591	162	171	14	2.3
Эмийн бүтээгдэхүүн	мян.ширхэг	2431.8	6774	8581.6	6540.6	2.6 дахин
Химийн бүтээгдэхүүн	тн	448	987.1	917.8	831.1	185.5
Хөнгөн блок	мян.ш	256.3	185.4	644.9	698.1	2.7 дахин
Төмөр бетон эдлэл	метр куб	0.6	1.900	1.800	1.634	2.7 дахин
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл	Мян.ш	2086.7	2201.3	2625.4	2743.5	131.4
Төмөр хаалга цонх	метр.кв	37.1	12	7.2	23.1	62.2

Тайлбар: Статистикийн албан ёсны мэдээнд хамрагдсан аж үйлдвэрийн газруудын дүн

Зураг 4. Хүнсний бус бүтээгдэхүүний үйлдвэрлэл, эдийн засгийн ангиллаар, сая төгрөгөөр



Аж үйлдвэрийн газрууд 2019 онд 4835.5 сая төгрөгийн хувцас үйлдвэрлэсэн нь 2016 оноос 2886.3 (2.4 дахин) сая төгрөгөөр, 21935.3 сая төгрөгийн химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2016 оноос 16674.3 (4.1 дахин) сая төгрөгөөр, 230 сая төгрөгийн резинен болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2016 оноос 68.2 (42.1%) сая төгрөгөөр, 8364.9 сая төгрөгийн төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэсэн нь 2016 оноос 6689.2 (4.9 дахин) сая төгрөгөөр, 3079.2 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэсэн нь 2016 оноос 1577.1 (2 дахин) сая төгрөгөөр өссөн байна. Харин 15.4 сая төгрөгийн мебель тавилга үйлдвэрлэсэн нь 2016 оноос 877.8 (98.3%) сая төгрөгөөр буурсан байна.

АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ

2019 онд аж үйлдвэрийн газруудын нийт борлуулалт 560619.0 сая төгрөгт хүрсэн бөгөөд 2016 оноос 279620.2 (99.5%) сая төгрөгөөр, 2017 оноос 210270.7 (60%) сая төгрөгөөр, 2018 оноос 70804.2 (14.4%) сая төгрөгөөр тус тус өссөн байна. 2019 оны аж үйлдвэрийн нийт борлуулалтын 501140.6 (89.4%) сая төгрөгийг хүнсний бүтээгдэхүүний борлуулалт, 59478.4 (10.6%) сая төгрөгийг хүнсний бус бүтээгдэхүүний борлуулалт эзэлж байгаа бөгөөд 2016 оноос 233992.4 (87.5%) сая төгрөгөөр, 2016 оноос 45627.8 (4.2 дахин) сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, эдийн засгийн ангиллаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	$\frac{2019}{2016}$ %
Боловсруулах аж үйлдвэр	280998.8	350348.3	489814.8	560619.0	199.5
Хүнсний бүтээгдэхүүн, архи ус, ундаа үйлдвэрлэл	267148.2	325196.1	455248.1	501140.6	187.5
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	25562.8	31041.9	78831.3	89697.5	3.5 дахин
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	64219.0	92336.4	137830.8	163502.1	2.5 дахин
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	67611.1	85763.8	94171.4	88644.1	131.1
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	41123.0	46252.2	57021.5	69248.7	168.3
Архи, ус, ундаа үйлдвэрлэл	68632.3	69801.9	87393.1	90048.2	131.2
Хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэл	13850.6	25152.1	34566.7	59478.4	4.2 дахин
Нэхмэлийн үйлдвэрлэл	-	-	-	610.1	-
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	2770.3	5664.3	7002.6	4850.2	175.0
Мод, модон эдлэл	272.4	89.7	-	-	-
Кокс, шингэн болон цацраг идэвхт түлш	-	-	-	20778.5	-
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4948.9	12618	16226.4	20314.2	4.1 дахин
Резинен болон хуванцар бүтээгдэхүүн	161.8	219.9	283.6	229.9	142.0
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	2234.4	3262.9	8524.4	9082.1	4 дахин
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	2444.4	2880.8	2256.2	2868.0	117.3
Автомашин, чиргүүл үйлдвэрлэл	-	-	-	730.0	-
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	1018.9	416.5	273.5	15.4	1.5

Тайлбар: Статистикийн албан ёсны мэдээнд хамрагдсан аж үйлдвэрийн газруудын дүн

Хүнсний бүтээгдэхүүний борлуулалт

Хүнсний бүтээгдэхүүний нийт борлуулалтын 17.8 хувийг мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 32.6 хувийг сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 17.6 хувийг үр тарианы гурил, малын тэжээлийн үйлдвэрлэл, 17.9 хувийг архи, ус, ундаа үйлдвэрлэл, 13.8 хувийг хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл эзэлж байна.


2019 онд мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрүүд 89697.5 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь 2016 оноос 64134.7 (3.5 дахин) сая төгрөгөөр, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрүүд 163502.1 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь 2016 оноос 99283.1 (2.5 дахин) сая төгрөгөөр, үр тариа, гурилын үйлдвэрүүд 88644.1 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь 2016 оноос 21033 (31.1%) сая төгрөгөөр, архи, ус, ундааны үйлдвэрүүд 90048.2 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь 2016 оноос 21415.9 (31.2%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүнсний бус бүтээгдэхүүний борлуулалт

Хүнсний бус бүтээгдэхүүний нийт борлуулалтын 1.0 хувийг нэхмэлийн үйлдвэрлэл, 8.1 хувийг хувцас үйлдвэрлэл, 34.9 хувийг кокс, шингэн болон цацраг идэвхт түлш үйлдвэрлэл, 34.1 хувийг химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 0.3 хувийг резинен болон хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 15.2 хувийг төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэлийн үйлдвэрлэл, 4.8 хувийг машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл, 1.2 хувийг автомашин, чиргүүл үйлдвэрлэл, 0.02 хувийг мебель тавилга үйлдвэрлэл эзэлж байна.

2019 онд аж үйлдвэрийн газрууд 4850.2 сая төгрөгийн хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалтын борлуулалт хийсэн нь 2016 оноос 2079.9 (75%) сая төгрөгөөр, 20314.2 сая төгрөгийн химийн бүтээгдэхүүний борлуулалт хийсэн нь 2016 оноос 15365.3 (4.1 дахин) сая төгрөгөөр, 9082.1 сая төгрөгийн төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэлийн борлуулалт хийсэн нь 2016 оноос 6847.7 (4 дахин) сая төгрөгөөр, 229.9 сая төгрөгийн резинен болон хуванцар бүтээгдэхүүний борлуулалт хийсэн нь 2016 оноос 68.1 (42%) сая төгрөгөөр, 2868.0 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэлийн борлуулалт хийсэн нь 2016 оноос 423.6 (17.3%) сая төгрөгөөр өссөн байна. Харин 15.4 сая төгрөгийн мебель тавилга үйлдвэрлэлийн борлуулалт хийсэн нь 2016 оноос 1003.5 (66.1 дахин) сая төгрөгөөр буурсан байна.


Зураг 5. Хүнсний бус бүтээгдэхүүний борлуулалт, эдийн засгийн ангиллаар, сая төгрөгөөр



Экспорт

2019 онд аж үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрүүд гадаадын зах зээлд нийт 45211.9 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь 2016 оноос 41679.9 (16.5 дахин) сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс 42405.1 сая төгрөгийн мах, махан бүтээгдэхүүн экспортлосон нь 2016 оноос 41458.0 (44.7 дахин) сая төгрөгөөр, 931.5 сая төгрөгийн архи, ус, ундааны бүтээгдэхүүн экспортлосон нь 2016 оноос 221.9 сая төгрөгөөр, 1875.3 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэлийн бүтээгдэхүүн бүтээгдэхүүн экспортлосон нь 2016 оноос 792.7 (73.2%) сая төгрөгөөр өссөн байна.

Зураг 6. Экспорт, дэд салбараар, сая төгрөгөөр



Танилцуулга бэлтгэсэн:
Мэргэжилтэн Б.Лхагвасайхан